

## ATG 6000

### BAUR Шатаах трансформатор



#### Гэмтлийн эсэргүүцлийг өөрчлөх зөөврийн төхөөрөмж

- Кабелийн байршлыг нь олоход хэцүү гэмтлийг олох батлагдсан аргуудтай
- Хүрэхэд хэцүү кабельтай үед өндөр хэрэгцээтэй
- Ажиллагааны найдвартай байдлыг хангах бат бөх хийцтэй
- Гэмтэл илрүүлэх түвшин тус бүрийн бие даасан гүйдэл, хүчдэлийн хяналттай

ATG 6000 Шатаах трансформаторыг нам болон дунд зэргийн хүчдэлтэй сүлжээн дэх кабелийн гэмтлийн эсэргүүцлийг бууруулахад ашигладаг. Энэ төхөөрөмж нь импульсийн рефлектометрийн аргаар өндөр эсэргүүцэлтэй, байршлыг тогтооход хэцүү, тасалдалтай гэмтлийг олоход амархан, бага эсэргүүцэлтэй гэмтэл болгон хувиргана.

Богино холболтын хамгаалалттай 5750 ВА-н тэнэмэл талбайн трансформатор нь тогтмол гүйдэлд хамгийн ихдээ 15кВ хүчдэл гаргах ба бүрэн битүүмжлэгдсэн 19 инчийн гэртэй. Гаралтын хүчдэлийг 8 түвшинд өөрчлөх боломжтой бөгөөд ачаалалтай үед ч түвшнийг сольж болно. Ингэснээр гаралтын хүчдэлийг олох гэж буй кабелийн гэмтэлд тохируулах боломжтой юм. Үүнээс гадна потенциометр ашиглан гүйдэл ба хүчдэлийг түвшин тус бүрд бие биеэс нь хамааралгүйгээр хязгаарлаж болно.

Шатаах процесс явуулсны дараа ATG 6000-т холбох боломжтой гадаад омметрийг ашиглан гэмтлийн эсэргүүцлийг тодорхойлж, нэмж түлэх эсэхийг үнэлэх боломжтой.

#### Онцлог

- Шатаах хүчдэл тогтмол гүйдлийн 15 кВ хүртэл
- Гаралтын гүйдэл 90 A<sub>rms</sub> хүртэл
- Оролтын дээд чадал 5750 ВА
- Гаралтын хүчдэлийг 8 түвшинд оновчтой тохируулна
- Бүрэн ачааллын үед хүчдэлийн түвшнийг сэлгэж болно
- Температур нэмэгдэхэд автоматаар унтарна
- Температур нэмэгдэхэд дуут дохио өгнө
- Автомат цахилалтын нэгж
- Өндөр хүчдэлд асахаас хамгаалах түгжээтэй
- DIN EN 50191 стандартад нийцсэн аюулгүй байдлын хяналтын нэгжтэй
- Гадаад ослын зогсоох нэгжийг холбох дохионы чийдэн бүхий залгуурын суурьтай
- Гадаад омметрийг холбох боломжтой
- Дангаар нь эсвэл BAUR-н кабелийн гэмтэл тогтоох системд дагалдуулах модулиар ашиглаж болно

## Техникийн өгөгдөл

|                                  |                                                         |                  |                  |
|----------------------------------|---------------------------------------------------------|------------------|------------------|
| Цахилгаан хангамж                | 200 – 260 В, 50/60 Гц                                   |                  |                  |
| Сонголт                          | 100 – 130 В, 50/60 Гц<br>гадаад<br>автотрансформатортой |                  |                  |
| Хамгийн их чадлын хэрэглээ       | 5750 ВА (богино холболтын үед)                          |                  |                  |
| Тогтмол гүйдлийн гаралтын хүчдэл | Хамгийн ихдээ 15 кВ                                     |                  |                  |
| Хувьсах гүйдлийн гаралтын хүчдэл | 90 A <sub>rms</sub>                                     | хувьсах гүйдлийн | тогтмол гүйдлийн |
|                                  | 23 A <sub>rms</sub>                                     | 60 В-д           | 5000 В-д         |
|                                  | 11 A <sub>rms</sub>                                     | хувьсах гүйдлийн | тогтмол гүйдлийн |
|                                  | 3.5 A <sub>rms</sub>                                    | 230 В-д          | 8500 В-д         |
|                                  | 2.0 A <sub>rms</sub>                                    | хувьсах гүйдлийн | тогтмол гүйдлийн |
|                                  |                                                         | 500 В-д          | 15000 В-д        |
|                                  |                                                         | хувьсах гүйдлийн |                  |
|                                  |                                                         | 1500 В-д         |                  |
|                                  |                                                         | хувьсах гүйдлийн |                  |
|                                  |                                                         | 2600 В-д         |                  |
| Тогтмол гүйдлийн гаралтын хүчдэл | Хамгийн ихдээ 15 кВ                                     |                  |                  |
| Хувьсах гүйдлийн гаралтын хүчдэл | Хамгийн ихдээ 14 мкФ                                    |                  |                  |
| Дотоод цэнэггүйжүүлэх эсэргүүцэл | 15 кОм                                                  |                  |                  |
| Орчны температур (ажлын)         | -20-аас +55 °С                                          |                  |                  |
| Хадгалах температур              | -30-аас +70 °С                                          |                  |                  |
| Хэмжээс (У x Ө x Ө)              | 519 x 656 x 400 мм                                      |                  |                  |
| Жин                              | 92 кг орчим                                             |                  |                  |

## Стандарт савлагаанд

- BAUR Шатаах трансформатор ATG 6000
  - HV холболтын кабель, 4 м, бэхэлгээтэй
  - Үндсэн тэжээлийн кабель, 5 м
  - Газардуулгын кабель, 4 м, газардуулгын хавчаартай
  - Хэрэглэгчийн гарын авлага

## Нэмэлт дагалдах хэрэгсэл

- ATG 6000-г агуулах зориулалттай 14 RU (622 мм) өндөр, 400 мм гүнтэй 19 инчийн рак (барилгүй)
- 19 инчийн ракны зөөврийн бариул (1 хос), 400 мм гүнтэй
- 19 инчийн ракны 4 дугуй, бэхэлсэн
- Цахилалт, газардуулгын саваа GDR 40-250
- Дохионы чийдэн бүхий гадаад ослын зогсоох төхөөрөмж, 25 м урттай холболтын кабель дагалдана
- Дохионы чийдэн бүхий гадаад ослын зогсоох төхөөрөмж, 50 м урттай холболтын кабель дагалдана
- Гадаах автотрансформатор, 110/230 В; 6.0 кВА



Та энэ бүтээгдэхүүний талаар илүү ихийг мэдэхийг хүсч байна уу?  
Бидэнтэй холбоо барина уу: [www.baur.eu](http://www.baur.eu) > **BAUR worldwide**

